

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГНАГ-2025/06-02-ШТА-НА

Чойбалсан хот 2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Батжаргал
Утас: 7058-4207, Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn
Аудитор М.Ухаанбилэг
Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn
Аудитор С.Төмөрхуяг
Утас: 7058-4207, Цахим хаяг: tumurkhuyags@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ 5 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСАН БАЙНА.....	5
1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөөгүй 5 төсөл, арга хэмжээ байна.....	5-6
1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй байна.....	6
1.3 Батлагдсан зураг, төсөвт алдаа гарсан, гүйцэтгэлийн шатанд зураг, төсөв удаа дараа өөрчлөгдөж байгаа нь авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг, төсөв төлөвлөлтийн шаардлагыг хангасан гэж дүгнэх боломжгүй байна.....	7-8
1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.....	8
БҮЛЭГ 2. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ЗАРИМ ШААРДЛАГА ШАЛГУУРЫГ ХАНГААГҮЙ 3 АЖ АХУЙ НЭГЖИЙГ ШАЛГАРУУЛСАН БАЙНА.....	9
2.1 Авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг ЗГ-ын 2023 оны 409 дүгээр тогтоолоор тогтоосон хугацаанаас 33 хоног хоцроож Зам, тээврийн хөгжлийн яамнаас Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн байна.....	9-10
2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулж ажилласан байна.....	10
2.3. Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг бүрэн хангаагүй 3 оролцогчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.....	10-13
БҮЛЭГ 3. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ЧАНАРГҮЙ ХИЙСНЭЭС 7 АЖИЛД ТАЛБАЙ ДЭЭРХ ГҮЙЦЭТГЭЛЭЭС САНХҮҮЖИЛТИЙГ НЬ 691.0 САЯ ТӨГРӨГӨӨР ИЛҮҮ ОЛГОСОН БАЙНА.....	13
3.1 Авто замын 7 ажлыг урьдчилан санхүүжүүлж, хийж гүйцэтгээгүй 691.0 сая төгрөгийн ажилд гүйцэтгэл бичин илүү санхүүжилт авсан байна.....	13-14
3.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн 6 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барилга угсралтын 1 ажил, автозамын 1 ажлыг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, 3 автозамын ажлын дуусах хугацаа 2025 онд дуусахаар хүлээгдэж байгаа бол гэрээг дүгнээгүй 1 барилга угсралтын ажил байна.....	14-15
3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй авто замын 6 ажил байна.....	15-16
3.4 Булган сумын Соёлын төвийн барилгыг ашиглагч байгууллага санхүүгийн бүртгэл, тайланд тусгаагүй, нэмэлт гэрээний төсөвт тусгагдсан тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн аваагүй байна.....	16-17
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	17
ДҮГНЭЛТ:	18
САНАЛ:	19
ЗӨВЛӨМЖ:	19
ТӨЛБӨРИЙН АКТ.....	20
АЛБАН ШААРДЛАГА.....	21-26
ТУШААЛ.....	27-28
ХАВСРАЛТ.....	29-31

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын стандарт
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НА	Нийцлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Тендер шалгаруулалтын зааварчилгаа
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
MNS	Mongolian national standard

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

**Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, 2025 оны “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийлээ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Дорнод аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаас 2024 онд хэрэгжүүлэхээр шилжүүлсэн төсөл, арга хэмжээ болон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, ЗДТГ, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, сумдын Засаг дарга захиалагч байгууллагууд, хяналт хэрэгжүүлсэн байгууллагууд, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудитыг гүйцэтгэлээ.

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт” болон МҮЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталж, 2021 оны А/81 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудитын бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Батжаргал, аудитор М.Ухаанбилэг, С.Төмөрхуяг, шинжээч мэргэшсэн төсөвчин С.Бат-Амгалан, авто замын мэргэшсэн инженер Б.Жавхлантөгс нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын дэд төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 29-ний дотор батлуулж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 04 дүгээр сарын 16-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж хэлэлцүүлэн, тайланг 04 дүгээр сарын 18-нд Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлжээ.

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ 5 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСАН БАЙНА.

1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөөгүй 5 төсөл, арга хэмжээ байна.

Төсвийн тухай хуульд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байхаар заасан байна.

Төсвийн тухай хуульд Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бэлтгэнэ гэж заасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн 6 төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан эсэхийг тулгаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Улсын хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан эсэх
XIV.1.19	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/	үгүй
XV.1.1.15	Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/	үгүй
XIII.1.1.197	Сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/	тийм /2.7 заалт, 3.1.4.1 ерөнхий боловсролын сургуулийн барилга барих/
XV.1.1.38	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/	үгүй
XV.1.1.77	Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/	үгүй
XV.1.1.94	Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/	үгүй

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Харьцуулсан судалгаанаас харахад 5 төсөл, арга хэмжээ нь Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Салбарын яамдын сайдын хөрөнгө оруулалтын багцын жагсаалтыг Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй тулган баталгаажуулаагүйгээс Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдахгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчим, 6 дугаар зүйлийн

6.10.3 улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх, гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

ҮАГ-ын нэгтгэсэн тайланд тусгуулах санал: Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг баталж байх.

1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй байна.

Төсвийн тухай хуульд төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байх, Мөн Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан үнэлгээг хийхээр заасан.

Улсын төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын 36 төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлэн аймгийн Засаг даргын 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 1/1040 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Улсын төсөвт тусгуулахаар хүргүүлсэн хөрөнгө оруулалтын 36 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ Улсын төсөвт батлагдсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны Захирагч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана.” гэж заасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Дорнод аймагт шинээр хэрэгжсэн авто замын 3 төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргаар дамжин уламжлагдаагүй, Зам, тээврийн яамны сайдын багцад батлагдаж, эрх шилжиж ирсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг даргын хүргүүлсэн саналд үндэслэхгүй хөрөнгө оруулалтыг төлөвлөн баталж байгаа нь салбарын яамдын сайд хөрөнгө оруулалтын багцын жагсаалтыг тухайн орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын жагсаалтад эрэмбэлсэн эсэхийг тулган баталгаажуулж улсын төсөвт тусгаагүйтэй холбоотой байна.

Дээрхээс дүгнэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд Дорнод аймагт шинээр хэрэгжсэн авто замын 3 төсөл, арга хэмжээний төлөвлөлт Сангийн сайдын 295 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын 2.1-т заасан төслийн үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны үе шатны дагуу хийгдээгүй байна.

ҮАГ-т нэгтгэсэн тайланд тусгуулах санал: Салбарын яамдын сайдын хөрөнгө оруулалтын багцад багтсан хөрөнгө оруулалтыг тухайн орон нутгийн ТЭЗ-ын хөрөнгө оруулалтын жагсаалтад эрэмбэлсэн эсэхийг тулган баталгаажуулж улсын төсөвт тусгах.

1.3 Батлагдсан зураг, төсөвт алдаа гарсан, гүйцэтгэлийн шатанд зураг, төсөв удаа дараа өөрчлөгдөж байгаа нь авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг, төсөв төлөвлөлтийн шаардлагыг хангасан гэж дүгнэх боломжгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэж заасан байна.

Тайлант онд хэрэгжсэн авто замын төсөл, арга хэмжээ нь Дорнод аймгийн төвд, барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь Булган, Баяндун сумдад хэрэгжсэн байна.

Хүснэгт 2

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэлийн шатанд батлагдсан зураг, төсөв өөрчилсөн тоо	
1	Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/	2	
2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/	3	
3	Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/	1	
4	Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/	Баянтүмэнгийн гудамжны авто замын хашлагыг шинэчлэх, ус зайлуулах суваг хоолойн ажил	2
		Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу хучилттай авто зам (Хэрлэн сум 7 дугаар баг)	1
		Содномдаржаагийн гудамжны 0.46 км босоо тэнхлэгийн авто зам Дорнод аймаг	2
		Дорнод аймаг Хэрлэн сум Хянганы гудамжны 0,96км авто замын барилын ажил	1
		Дорнод аймаг Хэрлэн сум Данриг Данжайлин хийдийн баруун урд уулзвараас эхлэн Цагдаагийн газрын баруун талаар хойд чиглэлд үргэлжлэх 1 км авто зам	2
		Хэрлэн сум, Эмнэлгийн бүсийн 0.58 км авто замын барилгын ажил	2
	Дорнод аймаг Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто зам	1	
дүн		17	

Эх сурвалж: Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт

Авто замын 10 төсөл, арга хэмжээний зураг, төсөвт нийт 17 удаа өөрчлөлт орсон байна. Зураг төсөл удаа дараа өөрчлөгдөж байгаа нь зургийн компани газар дээр

нь ажиллаагүй, дутуу ажилласнаас шалтгаалж зураг төслөө бүхэлд нь буюу хэсэгчлэн өөрчлүүлсэн асуудлууд гарсан байна. Мөн өөрчлүүлсэн зургаа захиалагч болон магадлалаар батлуулаагүй байна.

Баянтүмэнгийн гудамжны авто замын хашлагыг шинэчлэх, ус зайлуулах суваг хоолойн ажил - Зураг хийхдээ явган замын тоо хэмжээг дутуу тооцсон. Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу хучилттай авто зам (Хэрлэн сум 7 дугаар баг) - Төсөвт өртөг тооцохдоо бетоны тээврийн зайг алдаатай тооцсоноос үүдэн 78.0 сая төгрөг илүү төсөвлөсөн.

Батлагдсан зураг, төсөвт алдаа гарсан, гүйцэтгэлийн шатанд зураг, төсөв удаа дараа өөрчлөгдөж байгаа нь авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг, төсөв төлөвлөлтийн шаардлагыг хангасан гэж дүгнэх боломжгүй нөхцөлд хүргэж байна.

Аймгийн Засаг даргад зөвлөмж: Хөрөнгө оруулалтын зураг, төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч баталж, баталгаажуулж байх.

1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 3 дугаар зүйлийн 3.1.1-д “Төслийг төлөвлөх харилцааг энэ журмын 1.2.2-т заасан журам болон аргачлалд зааснаар зохицуулна”, 5 дугаар зүйлийн 5.3.5-д “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ” гэснийг үндэслэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хуулийн этгээдийн өмчлөлд шилжүүлэх хуулийн заалттай байна.

Хүснэгт 3

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх
XIV.1.19	Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/	Тийм
XV.1.1.15	Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/	тийм
XIII.1.1.197	Сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/	тийм
XV.1.1.38	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/	тийм

XV.1.1.77	Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/	тийм
XV.1.1.94	Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/	тийм

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн 6 төсөл, арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцсэн байна.

БҮЛЭГ 2. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ЗАРИМ ШААРДЛАГА ШАЛГУУРЫГ ХАНГААГҮЙ 3 АЖ АХУЙ НЭГЖИЙГ ШАЛГАРУУЛСАН БАЙНА.

2.1 Авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг ЗГ-ын 2023 оны 409 дүгээр тогтоолоор тогтоосон хугацаанаас 33 хоног хоцроож Зам, тээврийн хөгжлийн яамнаас Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ барилга байгууламжийн жагсаалт”-аас эрх нь орон нутагт шилжсэн 22,153.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ 2024-2025 онд хэрэгжихээр батлагдсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 409 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Монгол Улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг баталж 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт шилжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасан байна. Дорнод аймгийн Худалдан авах ажиллагааны газарт Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолд заасан хугацааг 33 хоногоор хоцроож буюу 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр эрх шилжүүлсэн байна.

Дорнод аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/736 дугаар захирамжаар үнэлгээний хороог байгуулсан байна. ЗГ-ын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг баталсан. Үүнд: харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 150.0 сая төгрөгөөр босго үнийг тогтоосны дагуу эрх шилжин ирсэн авто замын 3 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

ҮАГ-т нэгтгэсэн тайланд тусгуулах санал: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Засгийн газрын тогтоосон хугацаанд шилжүүлэх.

2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулж ажилласан байна.

Дорнод аймагт эрх нь шилжин ирсэн 3 авто замын ажил болон барилгын ажлын тендерийн баримт бичгийг Сангийн сайдын 2023 оны А/259 дүгээр тушаалаар батлагдсан жишиг баримт бичгийн дагуу боловсруулж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

2.3. Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг бүрэн хангаагүй 3 оролцогчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар Дорнод аймагт 22,153.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 авто замын ажлыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас аймгийн Засаг даргад тендер шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгчийг шалгаруулах эрхийг шилжүүлсэн байна.

Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт, /Дорнод Хэрлэн сум/ 9.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй замын ажлын газар зүйн байршлаас хамаарч ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5-т “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.” гэсэн заалтын хүрээнд 7 багцад хувааж зарласан байна.

Хүснэгт 4

№	Багц	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мянган төгрөг/
1	Багц 1.	Баянтүмэнгийн гудамжны авто зам	928.1
2	Багц 2.	Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамжны авто зам	1,587.4
3	Багц 3.	Содномдаржаагийн гудамжны авто зам	994.3
4	Багц 4.	Дорнод аймаг, Хэрлэн сум Хянганы гудамжны 0.96 км авто замын барилгын ажил	1,786.7
5	Багц 5.	Хэрлэн сум, Эмнэлгийн бүсийн 0.58 км авто замын барилгын ажил	1,321.6
6	Багц 6.	Дорнод аймаг, Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто зам	939.1

7	Багц 7.	Дорнод аймаг, Хэрлэн сум, "Данриг Данжайлин" хийдийн баруун урд уулзвараас эхлэн Цагдаагийн баруун талаар хойд чиглэлд үргэлжлэх 1 км автозам	1,596.6
Дүн			9,153.8

Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны судалгаа

Авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцогчдын ирүүлсэн баримт материалыг тендерийн баримт бичигтэй тулган шалгасан.

Хүснэгт 5

№	Төсөл, арга хэмжээний нэр	Тендерт шалгарсан аж ахуйн нэгж	ТББ-т заасан шаардлагын тоо	ТББ-т заасан шаардлага хангаагүй тоо	ТББ-ын шаардлагад нийцээгүй заалт
1	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/	"Чандмань тал" ХХК	16	1	19.1
2	Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/	"Чандмань тал" ХХК	15	1	19.1
3	Багц 1. Баянтүмэнгийн гудамжны авто зам	"Мянган тэмүүлэл" ХХК	17	2	19.1, 19.2
	Багц 2. Хүүхэд, эмэгтэйчүүдийн гудамжны авто зам	"Мянган тэмүүлэл" ХХК	17	2	19.1, 19.3
	Багц 3: Содномдаржаагийн гудамжны авто зам	"Эм эн эйч инженеринг" ХХК	17	0	0
	Багц 4. Дорнод аймаг, Хэрлэн сум Хянганы гудамжны 0.96 км авто зам	"Баянцогт зам" ХХК	17	0	0
	Багц 5. Хэрлэн сум, Эмнэлгийн бүсийн 0.58 км авто зам	"Булган өндөр" ХК	17	1	19.1
	Багц 6. Дорнод аймаг, Хэрлэн сумын 3 дугаар баг, аймгийн Музейн уулзвараас шинээр төлөвлөгдөж буй 1800 айлын хотхон, хороолол хүртэлх авто зам	"Эм эн эйч инженеринг" ХХК	17	0	0
	Багц 7. Дорнод аймаг, Хэрлэн сум, Данриг Данжайлин хийдийн баруун урд уулзвараас эхлэн Цагдаагийн баруун талаар хойд чиглэлд үргэлжлэх 1 км автозам	"Мянган тэмүүлэл" ХХК	17	1	19.1
дүн			150	8	8
Нийцээгүй заалтын эзлэх хувь			5.3%		

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Тендерт шалгарсан компаниудын тендерийн баримт бичигт заасан шаардлагын дагуу баримт материалыг ирүүлээгүйтэй холбоотой зөрчил 5.3 хувийг эзэлж байна.

Үүнд:

- Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/ замын ажлын тендерийг нээлттэй сонгон шалгаруулалтаар хоёр удаа зарлаж ажилласан байна. Эхний сонгон шалгаруулалтад оролцогч ирээгүй тул дахин зарлахад "Чандмань тал" ХХК болон

“Хулжийн гол” ХХК-ууд оролцохоор материал ирүүлсэн байна. Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг өгөгдлийн хүснэгт ТШЗ 19.1.4-т заасан хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаар шаардсан “Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний талаарх мэдээллийг Маягт-5-ын дагуу ирүүлэх ба одоо гүйцэтгэж байгаа дуусаагүй ажилтай бол тайлбар болон ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. Тендер шалгаруулалтад санал болгосон ажилтан, машин механизмын 30-аас дээш хувь нь 70 хувиас бага гүйцэтгэлтэй ажилд давхацсан тохиолдолд тухайн тендерээс татгалзана.” гэсэн заалтын мэдээллийг ирүүлээгүй “Чандмань тал” ХХК-ийг сонгон шалгаруулсан бөгөөд дээрх шаардлагыг хангасан “Хулжийн гол” ХХК-ийн тендерээс татгалзсан байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын 1.2-т “Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө холбогдох журмын дагуу ирүүлсэн тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага нийцэх эсэхийг хянан үзэж, шаардлагад нийцсэн тендерийг үнэлнэ.” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2,8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ 9.1 тэрбум төгрөгийн нийт төсөвт өртөгтэй, он дамжин хэрэгжих ажлын тендерт 4 ААН материал ирүүлсэн бөгөөд үнэлгээний хорооноос бүгдэд нь тендерийн шалгуур хангаагүй тухай мэдэгдэл 2024.02.26-ны өдөр хүргүүлсэнд “Чандмань тал” ХХК Сангийн яаманд гомдол гаргасан байна. Сангийн яамнаас “Чандмань тал” ХХК-ийн гомдлыг хянан үзээд үндэслэлтэй гэж үзээд ТБОНӨХӨАҮХАТХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэн байна. Үнэлгээний хороо дахин үнэлээд “Чандмань тал” ХХК болон түншлэгч “Харгуй зам” ХХК-ийг шалгаруулж 2024.04.03-ны өдөр гэрээ байгуулсан байна. Тендерт шалгарсан “Чандмань тал” ХХК болон түншлэгч “Харгуй зам” ХХК-уудын материалыг хянан үзэхэд тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-т “хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний талаарх шаардлага: ... маягт-5 “хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл”-ийн дагуу ирүүлэх ба одоо гүйцэтгэж байгаа дуусаагүй ажилтай бол тайлбар болон ажлын гүйцэтгэлийн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.” гэсэн шаардлагыг хангаагүй байна. Энэ нь ТБОНӨХӨАҮХАТХ-ийн “27.9.Багцтай тендер шалгаруулалтын багц тус бүрд үнэлгээ хийх ба оролцогч хоёр ба түүнээс дээш багцад хамгийн сайн тендер ирүүлсэн бол оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадавхыг магадална.”, 35.1-т “Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.” Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын 1.2-т “Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө холбогдох журмын дагуу ирүүлсэн тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага нийцэх эсэхийг хянан үзэж, шаардлагад нийцсэн тендерийг үнэлнэ.” гэсэн заалтуудыг тус тус мөрдөж ажиллаагүй байна.
- Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ тендерийн Багц 1, 2-т “Мянган тэмүүлэл” ХХК шалгарсан байна. Тендерт шалгарсан хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендерийн материалыг хянахад Хөдөлмөр аюулгүй ажиллагааны ажилтанд мэргэжлээрээ 3 болон түүнээс дээш жил ажилласан байх шаардлагыг хангахгүй нийгмийн даатгал төлөлт хоосон төлөвтэй, 0922 УН улсын дугаартай бульдозерын түрээсийн гэрээг ирүүлээгүй, хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний талаарх шаардлагад “Рун Хэ Жиү Жөү Констракшн Инженеринг” ХХК-тай байгуулсан доод бүтэц далангийн ажил гүйцэтгэх гэрээнд оролцож байгаа инженер техникийн ажилтны мэдээлэл болон тоног төхөөрөмжийн мэдээллийг ирүүлээгүй. гүйцэтгэл 75.0 хувь гэж мэдээлсэн ч захиалагчийн гүйцэтгэлийн тодорхойлолт ирүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн. Энэ нь тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1-д заасан шаардлагыг хангаагүй, Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын 1.2-т “Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө холбогдох журмын дагуу ирүүлсэн тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага нийцэх эсэхийг хянан үзэж, шаардлагад нийцсэн тендерийг үнэлнэ.” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.
- Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ тендерийн 5 дугаар багцад “Булган өндөр” ХХК шалгарсан байна. ТШЗ 19.1-д шаардсан Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл ирүүлэхдээ гүйцэтгэлийн хувь болон тэдгээр төсөл арга хэмжээнд оролцож байгаа инженер техникийн ажилтнуудын болон машин механизмын мэдээллийг болон ажлын гүйцэтгэлийн талаар захиалагчийн

тодорхойлолт ирүүлээгүй байна. Энэ нь тус төсөл арга хэмжээнд оролцож байгаа инженер техникийн ажилтнууд болон машин механизмууд давхардаж байгаа эсэх, бодит гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй нь ТШЗ 19.1.4-т заасан 70 хувийг давсан эсэх нь нотлогдохгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын 1.2-т "Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө холбогдох журмын дагуу ирүүлсэн тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага нийцэх эсэхийг хянан үзэж, шаардлагад нийцсэн тендерийг үнэлнэ." гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

- Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ тендерийн 7 дугаар багцад “Мянган тэмүүлэл” ХХК шалгарсан байна. “Мянган тэмүүлэл” ХХК-ийн тендерт шалгарсан материалд авто замын инженерээр санал болгосон иргэн нь “эдэлбэр газрын кадастр, газар зохион байгуулалт” мэргэжилтэй, хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл ирүүлэхдээ тухайн төсөл арга хэмжээний 1, 2 дугаар багцад шалгарч гэрээ байгуулсан бөгөөд захиалагчийн тодорхойлолтыг ирүүлээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ын 1.2-т "Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө холбогдох журмын дагуу ирүүлсэн тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага нийцэх эсэхийг хянан үзэж, шаардлагад нийцсэн тендерийг үнэлнэ." гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Худалдан авах ажиллагааны газарт зөвлөмж: Тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангасан оролцогчийг сонгон шалгаруулах.

БҮЛЭГ 3. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ЧАНАРГҮЙ ХИЙСНЭЭС 7 АЖИЛД ТАЛБАЙ ДЭЭРХ ГҮЙЦЭТГЭЛЭЭС САНХҮҮЖИЛТИЙГ НЬ 691.0 САЯ ТӨГРӨГӨӨР ИЛҮҮ ОЛГОСОН БАЙНА.

3.1 Авто замын 7 ажлыг урьдчилан санхүүжүүлж, хийж гүйцэтгээгүй 691.0 сая төгрөгийн ажилд гүйцэтгэл бичин илүү санхүүжилт авсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/, сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/, босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/, 7 багц бүхий Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ гэсэн автозамын 10 ажил, барилга байгууламжийн 2 ажил, нийт 12 төсөл арга хэмжээнээс авто замын 7 ажлыг урьдчилан санхүүжүүлж, хийж гүйцэтгээгүй 691.0 сая төгрөгийн ажилд гүйцэтгэл бичин илүү санхүүжилт авсан байна.

Хүснэгт 6

№	Төсөл, арга хэмжээний нэр	2024 онд олгосон санхүүжилт /сая төгрөг/	Үүнээс илүү олгосон санхүүжилт	Илүү олгосон магадалшгүй ажлын зардлын дүн	Гүйцэтгэл илүү авсан хувь
1	Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/	6,025.6	75.1		1.2%
	Багц 1. Баянтүмэнгийн гудамж /Баянтүмэнгийн гудамжны авто замын хашлагыг шинэчлэх, ус зайлуулах суваг хоолойн ажил/	727.1	133.8	4.8	19.1%
	Чойбалсан хот доторх хатуу	375.2	103.0		27.4%
	Багц 2. Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу хучилттай авто зам (Хэрлэн сум 7 дугаар баг)				

2	хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/	Багц 3. Содномдаржаагийн гудамжны 0.46 км босоо тэнхлэгийн авто зам Дорнод аймаг	788.8		7.4	0.9%
		Багц 4. Дорнод аймаг, Хэрлэн сум Хянганы гудамжны 0.96 км авто замын барилгын ажил	1359.9	62.9		4.6%
		Багц 5. Хэрлэн сум, Эмнэлгийн бүсийн 0.58 км авто замын барилгын ажил	383.7	94.4	1.1	24.9%
		Багц 7. Дорнод аймаг, Хэрлэн сум, Данриг Данжайлин хийдийн баруун урд уулзвараас эхлэн Цагдаагийн баруун талаар хойд чиглэлд үргэлжлэх 0.961 км авто зам	663.1	208.5		31.4%
НИЙТ		10,323.4	677.7	13.3	6.7%	

Эх сурвалж: Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт

Гүйцэтгэл илүү бичиж санхүүжилт авсан нь авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн “Ангад арвижих”, “Танил санаа” ХХК-иуд нь ажлын гүйцэтгэлийг бодитой дүгнээгүйгээс шалтгаалсан байна.

Хийгдээгүй ажилд гүйцэтгэл бичин илүү санхүүжилт авсан 691.0 сая төгрөгийн гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс шалтгаалан захиалагчийн хяналтын зардал 12.6 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Гүйцэтгээгүй 691.0 сая төгрөгийн ажилд гүйцэтгэл бичин илүү санхүүжилт авсан зөрчил болон захиалагчийн хяналтын зардлыг хэтрүүлсэн 12.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн.

3.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн 6 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний барилга угсралтын 1 ажил, автозамын 1 ажлыг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, 3 автозамын ажлын дуусах хугацаа 2025 онд дуусахаар хүлээгдэж байгаа бол гэрээг дүгнээгүй 1 барилга угсралтын ажил байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймагт эрх шилжиж ирсэн 6 төсөл, арга хэмжээнээс “Сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/” барилга угсралтын ажлыг хугацаанаас өмнө гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэж өгсөн.

Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/ автозамын ажлыг гэрээний хугацаанд багтааж 2024.12.16-нд улсын комисст хүлээлгэж өгсөн байна.

Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/ барилга угсралтын ажлыг хүлээж авах барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс нь 2024 оны 12 дугаар сарын 30-нд тус барилгыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авахаар шийдвэр гаргасан боловч үүрэг даалгаврын хэрэгжилтийг газар дээр нь очиж хянаагүй байна.

Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/ барилга угсралтын ажлыг хүлээж авахтай холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Үүрэг даалгаврын биелэлтийн хэрэгжилт 46% буюу хангалтгүй байна.
- Гүйцэтгэгчтэй 2023 оны 12 сарын 28-нд байгуулсан нэмэлт гэрээний төсөвт тусгагдсан тоног төхөөрөмжийг хүлээлцсэн акт байхгүй.

- Гүйцэтгэгч тал болон ашиглагч талаас гаргаж өгсөн тоног төхөөрөмжийн тоо хэмжээ зөрүүтэй байна.

Дорнод аймгийн Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага өгсөн.

3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй авто замын 6 ажил байна.

Автозамын ажлын төсвийг хянаж үзэхэд төсвийн нормыг буруу хэрэглэн тээврийн зайг буруу тооцоолж алдаа гаргасан, батлагдсан зураг төслийн дагуу хийгээгүйгээс шалтгаалсан 81.5 сая төгрөгийн санхүүжилт илүү авсан байна. Үүнд:

- Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ замын ажлын ПК0+000-ПК0+260 хооронд хучилтын өргөнийг 13.9 м буюу 0.1 м дутуу хийсэн. 3.5 сая төгрөг илүү авсан.

- Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ Багц 2: Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу хучилттай автозамын ажилд тээврийн зайг буруу авч тооцоноос 78.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү авсан.

Эх сурвалж: Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт

Батлагдсан зураг, төсвийн дагуу гүйцэтгээгүй, төсөв илүү бичиж авсан зөрчилд 81.5 сая төгрөгт төлбөрийн акт тогтоосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй авто замын 10 ажлын 3 нь өнгө, 1 нь суурь асфальтбетон хучилтаа авсан байгаагаас нийт 10 дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж үзэхэд 98%-ийн нягт авсан байх ёстой техникийн шаардлагын үзүүлэлтэд хүрээгүй байна. Мөн замын чанар байдалтай холбоотой дараах алдаа, зөрчлүүд гарсан байна. Үүнд:

1. Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/

- Батлагдсан зураг төсөлд заагдсанаас 0.1м нарийн хийсэн. ПК0+000-ПК0+260 хооронд 260 м

- Асфальтбетон хучилтын нягт хүрээгүй дутуу нягтруулсан.

- Асфальтбетон хучилтад нүхэн эвдрэл гарч хучилтын өнгөн хэсэг хууларч эхэлсэн нь тухайн үед 2024 оны 10 дугаар сард хучилтын ажлыг хийхдээ технологийн алдаа гаргасан.

- Гадаргуу тэгш бус хийгдсэн байна.

2. Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/

- Асфальтбетон хучилтын нягт хүрээгүй дутуу нягтруулсан.

- ПК5+200, ПК0+500 орчмын 2 тойргийн хучилтад нүхэн эвдрэл үүсэж асфальтбетон хучилтын чулуу суларч хучилтад эвдрэл үүсэж эхэлсэн.

3. Дорнод аймаг Хэрлэн сум Хянганы гудамжны 0.96 км авто замын барилын ажил

- Асфальтбетон хучилтын нягт хүрээгүй дутуу нягтруулсан.

- Ольхон зочид буудлын орчмын хучилтад нүхэн эвдрэл үүсэж асфальтбетон хучилтын чулуу суларч хучилтад эвдрэл үүсэж эхэлсэн.

4. Баянтүмэнгийн гудамжны авто замын хашлагыг шинэчлэх, ус зайлуулах суваг хоолойн ажил

- Борооны ус зайлуулах нүхтэй хашлагуудын нүхний тэгш хэм алдагдсан.

- Борооны усны зам доогуур нэвт гарсан сувгийн төгсгөлд тунгаах худаг суулгаагүй.

- Зураг хийхдээ явган замын тоо хэмжээг дутуу тооцсон.

5. Дорнод аймаг Хэрлэн сум Данриг Данжайлин хийдийн баруун урд уулзвараас эхлэн Цагдаагийн газрын баруун талаар хойд чиглэлд үргэлжлэх 0.961 км авто зам

- Авто замын уулзвар гудамжтай огтлолцож байгаа хэсгүүдийн хашлагуудыг зургийн дагуу хийгээгүй.

6. Дорнод аймаг, Хэрлэн сумын босоо тэнхлэг ба хотхоны авто зам барих ажил, Содномдаржаагийн гудамжны 0.46 км авто зам

- Суурь хучилт хийгдсэн. Асфальтбетон хучилтын нягт хүрээгүй дутуу нягтруулсан.

Эх сурвалж: Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт

Хөрөнгө оруулалтын ажлын чанар, гүйцэтгэлтэй холбоотой алдаа, зөрчил гарч байгаа нь захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс шалтгаалсан байна.

Төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллахыг Дорнод аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлсэн.

3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгөөс Булган сумын Соёлын төвийн барилгыг ашиглагч байгууллага санхүүгийн бүртгэл, тайланд тусгаагүй, хөрөнгийг бүртгэх тогтоол шийдвэр гараагүй байна.

Сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/ төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон бага сургууль, урлаг заалны барилгыг хөрөнгөөр бүртгэж санхүүгийн тайланд тусгасан байна.


Босоо тэнхлэг ба шинэ хотхоны авто зам /Дорнод, Хэрлэн сум/ төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон автозамыг “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 6.2-т заасан “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэсний дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-н үндсэн хөрөнгөөр бүртгэж санхүүгийн тайланд тусгасан байна.

Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/ төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон барилга дагалдах тоног төхөөрөмжийг гүйцэтгэгч тал болон ашиглагч талууд хүлээлцсэн акт үйлдээгүй ба хөрөнгөөр бүртгэж аваагүй байна.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг, төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3 Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: 2.3.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар: 2.3.1.10 төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа болон санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний **өмч бүртгэл**, ашиглалтыг хариуцан хэрэгжүүлэх;” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дорнод аймгийн Засаг даргад зөвлөмж: Төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэх ажлыг зохион байгуулах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4202, факс: 7058-4584
Цахим шуудан: azdtg@domod.gov.mn
Цахим хуудас: Domod.gov.mn

Б.Батмунууч
Мэдээлэл үзсэн
ЧЭТ-м үргүүлжээ

2025.04.01 № 1/936
танай _____-ны № _____-т

Б.Батмунууч ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.БОЛОРТУУЛ ТАНАА

“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн аудитын тайлангаар ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

~~ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ *Б.Батмунууч* Я.ТАНБАТ~~

2125070203

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөөгүй 5 төсөл, арга хэмжээ байна.

1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй байна.

1.3 Батлагдсан зураг, төсөвт алдаа гарсан, гүйцэтгэлийн шатанд зураг, төсөв удаа дараа өөрчлөгдөж байгаа нь авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зураг, төсөв төлөвлөлтийн шаардлагыг хангасан гэж дүгнэх боломжгүй байна.

1.4 Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцсэн, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

2.1 Авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг ЗГ-ын 2023 оны 409 дүгээр тогтоолоор тогтоосон хугацаанаас 33 хоног хоцроож Зам, тээврийн хөгжлийн яамнаас Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн байна.

2.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулж ажилласан байна.

2.3 Худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг бүрэн хангаагүй 3 оролцогчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.

3.1 Захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс авто замын 7 ажлыг урьдчилан санхүүжүүлж, хийж гүйцэтгээгүй 691.0 сая төгрөгийн ажилд гүйцэтгэл бичиж илүү санхүүжилт олгосон байна.

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлж, гэрээг дүгнээгүй 1 барилга угсралтын ажил байна.

3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй авто замын 6 ажил байна.

3.4 Булган сумын Соёлын төвийн барилгыг ашиглагч байгууллага санхүүгийн бүртгэл, тайланд тусгаагүй, нэмэлт гэрээний төсөвт тусгагдсан тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн аваагүй байна.

Аудитаар нийт 4,344.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 81.5 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 991.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 3,270.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгуулах 3 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлүүлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

Сангийн яаманд

1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг баталж байх.
2. Хөрөнгө оруулалтын багцад багтсан хөрөнгө оруулалтыг тухайн орон нутгийн ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын жагсаалтад эрэмбэлсэн эсэхийг тулган баталгаажуулж улсын төсөвт тусгах.

Зам, тээвэр хөгжлийн яамд

1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Засгийн газрын тогтоосон хугацаанд шилжүүлэх.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёл-д

1. Хөрөнгө оруулалтын зураг, төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч баталж, баталгаажуулж байх.
2. Төсөл, арга хэмжээг чанартай гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах, авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн аж ахуй нэгжүүдэд алдаа, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгөх.
3. Төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэх ажлыг зохион байгуулах.

Худалдан авах ажиллагааны газрын дарга Б.Саранчимэг-т:

1. Тендерийн баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангасан оролцогчийг сонгон шалгаруулах.

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан.

Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ТӨЛБӨРИЙН АКТ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 04 сарын 18

Актны дугаар: 64 ГНАГ-2025/06-02-ШТА-НА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, 2025 оны “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д нийцлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. “Чандмань Тал” ХХК-ийн гүйцэтгэсэн “Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/” замын ажлын ПК0+000-ПК0+260 хооронд хучилтын өргөнийг 0.1 метрээр бага буюу 3.5 сая төгрөгийн ажил дутуу хийсэн.

2. “Мянган Тэмүүлэл” ХХК-ийн гүйцэтгэсэн “Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ Багц 2. Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамжны авто замаас Мянгат хороолол чиглэлийн хатуу хучилттай авто зам”-ын ажилд тээврийн зайг буруу авч тооцоноос 78.0 сая төгрөгийн санхүүжилтийг илүү авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Автозамын тухай хуулийн 21.2-т Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэсний дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 228 дугаар тушаалын хавсралт “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын 5.5 Зөвлөх нь замын барилгын ажил хэрэгжилтийн хугацаанд тухайн ажлыг батлагдсан зураг төсөв, норм, норматив, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд өдөр тутам хяналт тавьж, ажлын чанар, гүйцэтгэлийг баталгаажуулан ажлын явцын талаарх мэдээллээр захиалагчийг хангана. Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2 Захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэсний 4.2.2.9 Төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлийн баримт бичиг, иж бүрдэл, түүний үнэн зөв эсэхэд бүрэн хариуцаж ажиллах гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2125050152

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.7 “Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан”, 4.2.3.5 “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Автозамын ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, төсвийн нормыг буруу тооцсоноос шалтгаалан илүү авсан санхүүжилт болох 81,499,070 /наян нэгэн сая дөрвөн зуун ерэн есөн мянга далан/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан дахь орон нутгийн торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёл, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Гэрэлцэцэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

АЛБАН ШААРДЛАГА:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 01/2025 ГНАГ-2025/06-02-ШТА-НА Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, 2025 оны “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д нийцлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Захиалагчийн хяналтыг чанаргүй хийснээс автозамын 7 ажилд талбай дээрх гүйцэтгэлээс санхүүжилтийг 691.0 сая төгрөгөөр илүү олгосон байна.

2. Хийж гүйцэтгээгүй ажилд гүйцэтгэл бичин илүү санхүүжилт авсан 691.0 сая төгрөгийн гүйцэтгэлийг бодитой хянаагүйгээс шалтгаалан захиалагчийн хяналтын зардал 12.6 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Авто замын тухай хуулийн 21.2 Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэсний дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 228 дугаар тушаалын хавсралт “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын 5.12 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санхүүжилтийн хүсэлтийг гэрээнд заасан хугацаанд хянан баталгаажуулна. Санхүүжилтийн хүсэлтэд алдаа гарсан тохиолдолд гүйцэтгэгчид буцаан засварлуулна. Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4 Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг: 4.4.1.5 Захиалагчийн техник, технологийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэжлийн түвшинд, чанартай, үр ашигтай, ил тод, нээлттэй болон хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд

2125040600

албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8 “Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авто замын төслийг гүйцэтгэгч нарт илүү санхүүжилт олгодог зөрчлийг давтан гаргахгүй байх, илүү олгосон санхүүжилт, захиалагчийн хяналтын хэтэрсэн зардал нийт 703,612,278 /долоон зуун гурван сая зургаан зуун арван хоёр мянга хоёр зуун далан найман/ төгрөгт тохирсон ажлыг нөхөн хийлгэж биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёл, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Гэрэлцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 02/2025 ТНАГ-2025/06-02-ШТА-НА

Чойбалсан хот

Г Зөрчил арилгах тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, 2025 оны “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/15 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д нийцлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/ барилга угсралтын ажлыг хүлээж авах барилга байгууламжийг ашиглалтад оруулах Улсын комисс нь 2024 оны 12 дугаар сарын 30-нд тус барилгыг үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авахаар шийдвэр гаргасан боловч үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, хэрэгжилтийг газар дээр нь очиж хянаагүй байна. Гүйцэтгэгчтэй 2023 оны 12 сарын 28-нд байгуулсан нэмэлт гэрээний төсөвт тусгагдсан 288.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлцсэн акт байхгүй.

2. Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүсээгүй байхад ажил гүйцэтгэх гэрээний хугацааг 2024 онд 4 удаа сунгасан.

Энэ нь Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйл, Засгийн газрын бүрэн эрх 32.1.7 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийг батлах гэсний дагуу Засгийн газрын 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоолын хавсралт: “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 8.1 Захиалагч, гүйцэтгэгч талууд илэрсэн зөрчил дутагдлыг ажлын 14 өдөрт багтаан арилгаж, комиссын хуралдаанаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ. 8.2 Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана. 8.2.1 Барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт, 8.2.2 Энэ дүрмийн 5.1, 6.1-д заасан шаардлага хангаагүй, 8.1-д заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангагдаагүй тохиолдолд татгалзсан дүгнэлт. Мөн Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/259 дүгээр тушаалын хавсралт “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн гэрээний ерөнхий нөхцлийн 4.5 Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах

2125040610

тухай хүсэлт гаргаж болно гэсний 4.5.1 Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон. Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4 Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг: 4.4.2 Төсөл, арга хэмжээг хуулиар баталсан хугацаанд бүрэн ашиглалтад оруулахад захиалагчийн техник, технологийн хяналтын чиг үүргийг гэрээний дагуу үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэх гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8 “Байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй,” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээг тогтоосон хугацаанд дуусгахад хяналт тавьж ажиллах.

2. Соёлын төвийн барилга, 200 суудал /Дорнод, Булган сум/ барилга угсралтын ажлыг хүлээж авах барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгавраар өгсөн ажлуудын биелэлтийг хэрэгжүүлэх, тоног төхөөрөмжийг бүрэн хүлээлгэж өгөх, ашиглалтад бүрэн оруулахад хяналт тавьж биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Засаг дарга Ш.Ёл, Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Гэрэлцэцэг нарт нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/16

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газрын дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Б.Батжаргалд даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

2125010017


Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны
4 дүгээр сарын 18-ны өдрийн
А/16 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Төлбөрийн актын жагсаалт

№	Байгууллагын нэр	Төлбөрийн актын дугаар	Төлбөрийн актын дүн /сая.төг/
1	Дорнод аймгийн ЗДТГ	64 ГНАГ-2025/06-02-ШТА-НА	81.5
Дүн			81.5

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2025 оны
4 дүгээр сарын 18-ны өдрийн
А/16 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Албан шаардлагын дугаар	Албан шаардлагын дүн /сая.төг/
1	Дорнод аймгийн ЗДТГ	01/205 ГНАГ-2025/06-02-ШТА-НА	703.6
2	Дорнод аймгийн ЗДТГ	02/206 ГНАГ-2025/06-02-ШТА-НА	288.1
Дүн			991.7

ХАВСРАЛТ:



ЧАНДМАНЬ ТАЛ ХХК
EST. 1993

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Равдангийн гудамж, 1-р баг, Чойбалсан хот, 21061, Дорнод аймаг
Утас: 99112480, 88067746, И-мейл: chandmanital.llc@gmail.com

2025-04-18 № 01/94
танай -ны -Т

Тайлбар гаргах нь

Зам, тээврийн яамны захиалгаар 2024-2025 онуудад Дорнод аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулан / Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинжлэл 2,8км авто замын барилга угсралтын ажил /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ авто замын барилга барих ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд тус ажлын гүйцэтгэлд ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР-аас томилогдсон шинжээчийн тайлантай 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр танилцлаа.

Уг тайланд тусгагдсан манай байгууллагын гүйцэтгэж байгаа / Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл 2,8км авто замын барилга угсралтын ажил /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ авто замын барилга барих ажлын Асфальтбетон хучилтын нягт итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж үзэхэд 98% нягт авах ёстой байхад нягт шаардлага хангаагүй гэж тайланд тусгагдсан байна. Бид Ангад арвижих-ХХК буюу зөвлөх компани, захиалагчийн хяналт гүйцэтгэгч нарт танилцуулж гүйцэтгэлийн явцад байнга Асфальтбетон хучилтын нягт итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж, Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн №298 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлийг баримт бичиг, фото зураг акт, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтээр баталгаажуулж энэхүү гэрээт ажлыг гүйцэтгэсэн.

Мөн 2024 оны 10 сард хучилтын ажил хийхдээ технологийн алдаа гаргаж алсфальтбетон хучилтад хучилтын өнгөн хэсэг 2025 оны 04 сард хууларч эхэлсэн уг зөрчлийг бид байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллахаас өмнө бүрэн засварлана.

Иймд та бүхний тайланд тусгагдсан зөрчилийг түргэн хугацаанд засварлаж, хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтээр баталгаажуулан хүргүүлнэ.

Хувийг:

Дорнод аймгийн Төрийн аудитын газарт

Үндэсний аудитын газрын шинжээч Бат-Аюулан

ЗАХИРА



Ж.ЭНХБОЛД



ЧАНДМАНЬ ТАЛ ХХК
EST. 1993

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Равдангийн гудамж, 1-р баг, Чойбалсан хот, 21061, Дорнод аймаг
Утас: 99112480, 88067746, И-мэйл: chandmanital.lc@gmail.com

2025-04-18 № 01/95
танай -ны -т

Тайлбар гаргах нь

Зам, тээврийн яамны захиалгаар 2024-2025 онуудад Дорнод аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулан / Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5,5 км /Дорнод, Хэрлэн сум/ авто замын барилга барих ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд тус ажлын гүйцэтгэлд ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР-аас томилогдсон шинжээчийн тайлантай 2025 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр танилцлаа.

Уг тайланд тусгагдсан манай байгууллагын гүйцэтгэж байгаа /Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5,5 км /Дорнод, Хэрлэн сум/ авто замын барилга барих ажлын Асфальтбетон хучилтын нягт итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж үзэхэд 98% нягт авах ёстой байхад нягт шаардлага хангаагүй гэж тайланд тусгагдсан байна. Бид Танил санаа-ХХК буюу зөвлөх компани, захиалагчийн хяналт гүйцэтгэгч нарт танилцуулж гүйцэтгэлийн явцад байнга Асфальтбетон хучилтын нягт итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийж, Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн №298 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлийг баримт бичиг, фото зураг акт, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтээр баталгаажуулж энэхүү гэрээт ажлыг гүйцэтгэсэн.

Мөн ПК5+200, ПК0+500 орчмын 2 тойргийн хучилтад нүхэн эвдрэл үүсэж асфальтбетон хучилтын чулуу суларч эвдэрсэн гэсэн зөрчил илэрсэн гэж тайланд тусгагдсан байна. Уг зөрчлийг бид баталгаат засвар арчлалтын хугацаанд бүрэн засварлана.

Иймд та бүхний тайланд тусгагдсан зөрчилийг түргэн хугацаанд засварлаж, хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтээр баталгаажуулан хүргүүлнэ.

Хувийг:

Дорнод аймгийн Төрийн аудитын газарт

Үндэсний аудитын газрын шинжээч Бат-Амгалан

ЗАХИРАЛ



Ж.ЭНХБОЛД



“МЯНГАН ТЭМҮҮЛЭЛ” ХХК
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
5-р хороо, 10-р хороолол, АОС – 05 тоот
Утас: 976-95111193, 976-72201193
И-мэйл: info@myangantemuulel.mn
2025.04.18 № 67
танай _____ ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Г Хүсэлт гаргах тухай Г

Манай “Мянган тэмүүлэл” ХХК нь Дорнод аймаг дахь “Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт (Дорнод, Хэрлэн сум)” 2 дугаар багц “Хүүхэд эмэгтэйчүүдийн гудамж” ЗТХЯ/20240101064 УТ-ХV.1.1.94 Б2 дугаартай гэрээт ажлын сонгон шалгаруулалтад шалгарч уг төслийн ажлыг хийж гүйцэтгэж байна. Манайх дээрхи ажлын тендерт оролцох төсөвөө хийхэдээ тендрийн нэгдсэн төсөвт тусгагдсаныг удирдлага болгон төсөвтөө В-15 бетоны зөөвөрийн зайг 730 км зайнаас тооцож алдаа гаргасан нь Төрийн аудитын шалгалтаар илэрсэн бөгөөд зөрчлийг хүлээн зөвшөөрч байна. Уг төсвийн алдаанаас болж манай төсвөөс тээвэр болон цалин, удирдлагын зардалын зөрүү нийт 81.5000.000 (наян нэгэн сая таван зуун мянга) төгрөг хасагдахаар болсон.

Манай компанийн тендерт шалгарсан төсөвт өртгийн дүн бодит төсөв зардалд нийцэх бөгөөд төсөвөө хийхэд дээрхи зардалыг бусад бараа материалын зардалдаа гүйлгэж тохируулага хийгээгүй алдаанаас болж манай компани хохирол үзэх нөхцөл үүсээд байна.

Мөн уг ажлын зураг төсөв нь 2021 онд батлагдсан ба зураг төсөвт төсөвлөсөн бараа материал, асфальт, бетон, цалин хөлс, түлш шатахууны үнэ 2025 оны байдлаар нэг дахин нэмэгдсэн байгаа тул уг ажлыг хийж гүйцэтгэхэд төсвийн хувьд хүндрэлтэй байгаа билээ. Иймд дээрхи төсвийн алдаанаас үүссэн 81,500,000 (наян нэгэн сая таван зуун мянга) төгрөгийн төлбөрийн акт тогтоосон төсөвийг хасахгүйгээр бусад бараа материалд гүйлгэн алдаагаа засч төсөвийг дахин шинэчлэн хийх боломжыг олгож бидний ажилд туслалцаа үзүүлж өгнө үү.

ХҮНДЭТГЭСЭН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.БУЯНЖАРГАЛ

ДОРНОД АЙМАГ, ХЭРЛЭН СУМ, 7-Р БАГ АЙМГИЙН ЗДТГ-ЫН БАЙР
УТАС: +976 7058-4203, 7058-4204, 7058-4207
И-МЭЙЛ: DORNOD@AUDIT.GOV.MN , ВЕБ САЙТ: WWW.AUDIT.MN